



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2022 оны 07 сарын 11 өдөр

Дугаар 1/13

Мандалговь

Үнэлгээний хорооны гишүүдээс чөлөөлж,  
нөхөн томилох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийн 47.1, 47.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар санхүүжих “Аймгийн төвийн хяналтын камерын нэгдсэн системийн зураг төсөв боловсруулах” зөвлөхийн үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга Э.Энхжаргал (Аймгийн Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн) нь ажлаас чөлөөлөгдсөн, үнэлгээний хорооны гишүүн Н.Мөнгөний АЗ сертификатны хүчинтэй хугацаа дууссан тул үнэлгээний хорооноос чөлөөлсүгэй.

2. Тус ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны нарийн бичгийн даргаар М.Бат-Эрдэнэ (Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн), үнэлгээний хорооны гишүүнээр Ж.Элбэгзаяа (Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын мэргэжилтэн) нарыг нөхөн томилсугай.

3.Тендер шалгаруулалтыг холбогдох хууль, журмын дагуу шуурхай зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга /Ж.Гантулга/-д үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Л.ДОРЖБАТ

4020150017